

## ТАНИЛЦУУЛГА

Хүнсний барааны үнийн 2018 оны 6-р сарын 27-ны өдрийн ажиглалт


Нийслэлийн төвийн 6 дүүрэгт байрладаг 12 хүнсний зах, худалдааны төвд хийсэн 33 нэр төрлийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн 2018 оны 6-р сарын 4-р долоо хоногийн ажиглалтаар өмнөх долоо хоногоос 7 нэрийн барааны үнэ **тогтвортой**, 14 нэрийн барааны үнэ **буурсан**, 12 нэрийн барааны үнэ **өсжээ**. Үүнд :

≈ Үнэ тогтвортой	⇩ Үнэ буурсан	⇧ Үнэ өссөн
<ul style="list-style-type: none"> <li>• "Алтан Тариа" задгай гурил I</li> <li>• "Алейка" гурил дээд</li> <li>• Талх, "Атар"</li> <li>• Талх, "Зууван чех"</li> <li>• Талх, "хөх тарианы хар"</li> <li>• Цөцгийн тос, Сүү ХК</li> <li>• Ногоон цай, "Гүрж"</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• "Алтан Тариа" савласан гурил дээд</li> <li>• "Алтан Тариа" савласан гурил I</li> <li>• "Сүү" ХК хайрцагтай 1 л сүү</li> <li>• Сүү, задгай</li> <li>• Тараг, Цөцгийтэй</li> <li>• Цагаан будаа</li> <li>• Ургамлын тос, "Янта"</li> <li>• Элсэн чихэр</li> <li>• Хонины мах, цул</li> <li>• Үхрийн мах, цул</li> <li>• Адууны мах, ястай</li> <li>• Хүрэн манжин, монгол</li> <li>• Сонгино, хятад, бөөрөнхий</li> <li>• Өндөг, ОХУ</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• "Алтан Тариа" задгай гурил дээд</li> <li>• "Алтан Тариа" савласан гурил дээдийн дээд</li> <li>• "Алтан Тариа" савласан гурил II</li> <li>• "Сүү" ХК савласан 0.5 л сүү</li> <li>• Шар будаа</li> <li>• Хонины мах, ястай</li> <li>• Үхрийн мах, ястай</li> <li>• Ямааны мах, ястай</li> <li>• Төмс, монгол</li> <li>• Лууван, монгол</li> <li>• Байцаа, монгол</li> <li>• Алим, фүжи</li> </ul>

### Махны дундаж үнэ

2018 оны 6-р сарын 4-р долоо хоногт хонины ястай мах нэг килограмм нь дунджаар 7545 төгрөг, үхрийн ястай мах нэг килограмм нь дунджаар 9035 төгрөгийн үнэтэй байна. Үхрийн ястай махны үнэ өмнөх долоо хоногтой харьцуулахад 115 төгрөгөөр (1.3%) өсч, харин үхрийн цул махны үнэ 60 төгрөгөөр (0.6%) буурсан байлаа. Энэ долоо хоногийн ажиглалтаар үхрийн мах "Хархорин" хүнсний захад хамгийн хямд буюу 7500 төгрөг, Харин "Меркури" хүнсний захад хамгийн өндөр үнэтэй буюу 10500 төгрөг байна.

Зураг 1. Үхрийн махны дундаж үнэ, 1 кг



## Хүснэгт 1. Нэг килограмм махны жижиглэн худалдах дундаж үнэ, төгрөг


Үхрийн мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2013	7335	8025	7895	8330	8380	8275	8225	7710	7825	7245	7115	7280
2014	7980	7775	8425	8370	8685	8730	7955	7590	7635	7550	7495	7465
2015	7415	7565	7810	8080	8145	8445	7985	7230	7005	5975	5620	5520
2016	6165	6875	7105	8170	8495	7930	6950	6865	6120	5235	5495	5580
2017	6775	7405	7785	7985	8230	7905	7725	7375	7250	6945	6710	6505
2018	6615	7110	7740	8365	8465	9035*						

Хонины мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2013	6480	7095	7060	7420	7490	7470	7415	6710	6540	6215	6085	6245
2014	6855	6675	7040	7630	7800	7685	7030	6585	6395	5965	5835	5940
2015	5860	6140	6735	7460	7555	7455	6830	6050	5540	4510	4200	3930
2016	4625	5495	5970	6935	6945	6525	5780	5605	4940	4250	3945	4390
2017	5650	6030	6675	7080	7235	6700	6575	6395	6210	5760	5380	5140
2018	5240	5945	6560	7290	7490	7545*						

\* 4-р долоо хоногийн ажиглалтаар

## Зураг 2. Хонины махны дундаж үнэ, 1 кг



Өмнөх долоо хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ 55 төгрөгөөр (0.7%) өсч, харин хонины цул махны үнэ 165 төгрөгөөр (2.1%) буурсан байна. Энэ долоо хоногийн ажиглалтаар хонины мах “Хархорин” хүнсний захад хамгийн хямд буюу 6300 төгрөгөөр, харин “Меркури” хүнсний захад хамгийн өндөр үнэтэй буюу 9500 төгрөгөөр худалдаалж байна.


## Гурилын үнэ




2018 оны 6-р сарын 4-р долоо хоногт нийслэлийн хүнсний томоохон зах, дэлгүүрт “Алтан тариа” савласан нэг кг гурилын үнэ дээд зэрэг нь 1250-1430 төгрөг, 1-р зэргийнх 1000-1110 төгрөг, 2-р зэргийнх 819-900 төгрөг байна.

Худалдан авагч олон байдаг “Хүчит шонхор”, “Таван эрдэнэ”, “Бөмбөгөр”, “Баянзүрх”, “Хархорин” хүнсний захуудад задгайгаар буюу шуудайгаар худалдаж буй нэг кг дээд зэргийн “Алтан тариа” гурилын үнэ 1300 төгрөгийн үнэ ханштай байна. Харин “Барс” хүнсний захад дээд зэргийн “Алтан тариа” гурил 1250 төгрөг, 1-р зэргийн гурил 950 төгрөгөөр тус тус зарагдаж байна.

Зураг 3. Дээд зэргийн гурилын үнэ, 1 кг



Зураг 4. Савласан гурилын үнэ, 1кг



“Атар” талх хүнсний зах, дэлгүүрт 1100-1210 төгрөгийн үнэтэй байна. “Бөмбөгөр”, “Оргил”, “Хархорин” хүнсний захуудад “Атар” талхыг хамгийн хямд буюу 1100 төгрөгөөр, харин “Сансар” супермаркетэд хамгийн өндөр үнээр буюу 1210 төгрөгөөр худалдаалж байна.

**Хүнсний ногооны үнэ**

2018 оны 6-р сарын 4-р долоо хоногт өмнөх долоо хоногтой харьцуулахад хүрэн манжин 110 төгрөгөөр (2.4%), хятад сонгино 40 төгрөгөөр (3.0%) буурч, Харин монгол төмс 480 төгрөгөөр (34.8%), лууван 265 төгрөгөөр (10.9%), байцаа 815 төгрөгөөр (38.4%) тус тус өссөн байна.

Зураг 5. Нэг кг хүнсний ногооны дундаж үнэ, төгрөг



**Хэрэглээний үнийн ажиглалтын хавсралт хүснэгт:**

- Хавсралт 1. Хүнсний барааны үнийн ажиглалт, хүнсний зах, худалдааны төвөөр, 2018.VI.27
- Хавсралт 2. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2018 оны IV, V, VI сар
- Хавсралт 3. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2012-2018 оны VI сарын 27
- Хавсралт 4. Шатахуун, түлшний үнэ, ШТС-аар, 2018.VI.27
- Хавсралт 5. Шатахууны үнийн зэрэгцүүлэлт, 2018 оны IV, V, VI сарын ажиглалтаар
- Хавсралт 6. Шатахууны үнэ өөрчлөгдсөн өдөр, 2017-2018 он
- Хавсралт 7. Түлшний дундаж үнэ, худалдаж буй байршлаар, 2018.VI.27